

**“ХӨРШ БОЛОВЧ ХАМТДАА БУС...”
ДЭЛХИЙН ХОЁРДУГААР ДАЙНЫ ҮР ДҮН:
АР ӨВӨР МОНГОЛЫГ НЭГТГЭХ
АСУУДЛЫН ТУХАЙД**

Геннадий Васильев¹

Зохиогч энэхүү өгүүлэлдээ Дэлхийн хоёрдугаар дайны дараа Ар Өвөр монголыг нэгтгэх боломжийн тухай зарим асуудлыг хөндсөн юм. Өгүүлэлдээ уг асуудлаар ЗХУ-ын баримталж байсан байр суурийн талаар зарим баримт сэлт, мөн уг санал нь эрх зүйд нийцэж байсан гэсэн зарим түүхчдийн үзэл санааг тусгажээ.

Түлхүүр үг: Панмонголизм, нэгтгэх, Хятад улс, Монгол улс, Япон улс, Крымын бага хурал.

*Аливаа үйл явдлаас холдох тусам хүний оюун ухаан
“ийм байж болох байсан” гэсэн ганхаж хувирсан бодлоос
“ийм байх ёстой байсан” гэсэн тодорхой бодол,
“ийм байсан юм” гэсэн хатуу бодол руу аажимдаа шилждэг...
Анатолий Кони, оросын хуульч, нийгмийн зүтгэлтэн*

Оросын болон барууны тэргүүлэх монгол судлаачдын үздэгээр ХХ зууны эхэн, дунд үеийн түүхэн үйл явдал, тухайлбал бүх монгол туургатан үндэстэн ястнуудыг нэгтгэн нэг улс байгуулахын төлөө хөдөлгөөн өнөөгийн монгол хятадын харилцаанд их бага хэмжээгээр тусч нөлөөлдөг. Уг асуудал нь түүхийн гүнзгий үндэс суурьтай байдаг хийгээд уг асуудлын тараар эрдэмтэд, улс төрчид өөр өөр өнцгөөс тайлбарладаг тул шинжлэх ухаанд үлэмж ач холбогдолтой сэдэв

¹ Байгалийн чанад дахь хязгаарын Улсын их сургууль, Зүүн хойд азийг судлах олон улс судлалын эрдэм шинжилгээний төвийн захирал. Чита хот, ОХУ

гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйн хэрэг.

Панмонголизм гэгч ойлголт нь юуны өмнө монгол туургатан бүхий л үндэстэн ятснуудыг нэгтгэж “Их Монгол Улсыг” байгуулж Чингис хааны үеийн их гүрний уламжлалыг сэргээх гэсэн шашин, угсаатаны хөдөлгөөн юм. XX зууны эхний хагасад энэ санаа нэг бол хоёрдугаар зэргийн асуудал болж, эргээд Монгол Улсын Хятад болон Орос улстай харилцах харилцаанд эргэж хөндөгддөг. Хэдий тийм ч энэ асуудлыг олон улсын нэг ч бага хурал дээр их бага хэмжээгээр хөндөж хэлэлцэж байгаагүй юм. Монголын нэгдсэн улсын бүрэлдэхүүнд байх үндэстэн ястаныг нэрлэх нь түүхэн болон бусад хүчин нөхцөлийн улмаас өөрчлөгдөх боловч асуудлын гол үзэл болох ар, өвөр монголын нэгдэх асуудал ямагт оршоор байна.

Панмонголизмын асуудал нь улс төрийн бодит үзэгдэл гэдэг утгаараа анх 1911-1912 онд болж өнгөрсөн үйл явдлын үед гарч ирсэн юм. Тэр нь монголын язгууртнуудын өөрийн уриаг бүрэн гүйцэлдүүлэх гэсэн анхны оролдлого болж байлаа. 1911 оны 12-р сарын 11-ний өдөр монголын ноёд, дээд зиндааны лам нар Монгол Улсын тусгаар тогтнолыг тунхаглан зарлав. Нийслэл Өргөөгөөс Хятадад буй монголчуудын бүхий л газар нутаг руу монголчуудыг хоорондоо эвсэн тусгаар тогтноссон халхчуудтай нэгдэхийг уриалсан уриа захидалтай буухиа мордуулав. Төдөлгүй баргууд болон Манжуурт буй монголчууд уриаг хүлээн авсан тухайгаа мэдэгдэж, 1912 оны 1-р сард тэд тусгаар тогтнолоо зарлаж Ар монголтой нэгдсэн тухайгаа мэдэгдэв. 1912 оны 8-р сард Өвөр монголыг чөлөөх хөдөлгөөнийг хоошуу ноён Удай удирдах болов. Бослоготой холбогдуулж Хаант оросын Гадаад хэргийн сайд С.Д.Сазонов: “Өвөр монголыг Хятадаас салгах гэсэн хөдөлгөөнийг бид таашаахгүй, эл хөдөлгөөн өргөжин газар авахыг дэмжихгүй” гэж мэдэгдэв. 9-р сарын эхээр хятадын эрх баригчид бослогыг дарав. Бослого бүтэлгүй болсны гол шалтгаан нь өвөр монголд хятадын нөлөө үлэмж байсан хийгээд Орос улс уг бослогод цэрэг зэвсгийн тусламж үзүүлэхээс татгалзсан, бослогод бэлтгэх ажлыг муу зохион байгуулсан, босогчдын тоо бага байсан зэрэг юм.

1911-1915 онд Хятадын хязгаар нутагт болсон үйл явдалуудын ач холбогдол нь гэвэл хэдийгээр 1905-1910 онд монголчуудын газар нутагт Хятадын худалдаа эдийн засгийн нөлөө улам бүр хүчтэй

болсон ч монголын язгууртнууд панмонголизмын үзэл санааг сэргээж монголын төр улс, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн зэвсэг болгож чадсан явдал юм. Нөгөө талаас тэр үед болж өнгөрсөн үйл явдлууд Петербург болон Нийслэл Өргөө хоёрын харилцаанд ноцтой зөрөлдөөн байсныг ухан гаргаж ирэв. Монголчуудын год зорилгуудын нэг болох монгол туургатныг нэгтгэх гэсэн үзэл санааны талаар оросын засгийн газрын тэргүүн Амар мөрний чанад дахь тойргийн засаг даргад: "... тэр хэсэгт байгаа монголчуудын тусгаар тогтнолыг Орос улс хамгаалахгүй" хэмээн бичиж байв. Тэр үед Өргөөгөөс явуулж байсан гадаад бодлогын онцлог нь панмонголизмын үзлийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааг гүйцэлдүүлсэн ч шинэ эрч хүчний сэргэлтийн давалгаа эхлээгүйд байлаа. 1915-1917 онд монголын удирдагчид гурвалсан гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж байгаагүй ч өвөр монголын удирдагчидтай холбоо харилцаагаа үргэлжлүүлсэн хэвээр байсан юм.

Панмонголизмын ээлжит идэвхжилт 1919 онд үүсэв. Гэхдээ энэ удаад монголчуудыг нэгтгэх санаачлагч нь Япон улс, мөн цагаантны хөдөлгөөний удирдагч атаман Семёнов, барон Унгерн нар байв. Тэдний хувьд панмонголизмын үзэл нь Төв Азид өөрсдийнхөө байр суурийг олж бэхжүүлэх, улмаар Хятадад нөлөөгөө өргөтгөх түшиц газраа болгох хэрэгслэл нь байлаа. 1919 оны 2-р сарын 25-ны өдөр Чита хотод буриад, өвөр монгол, баргын төлөөлөгчид оролцсон панмонголизмын их хурлыг нээж хуралдуулав. Их хурлаас Монголын их хуралдайг Хайлаар хотод төвтэйгээр байгуулсныг зарлав. 1911-1919, 1925-1927 онд болсон үйл явдлууд нь ХХ зууны эхэнд Зүүн хойд азийн ард түмнүүдийн үндэстэн болон төр улсаа тодорхойлж байр өөрийн сууриа олох гэсэн үйл явцын гинжин урвалын нэг холбоос нь байсан юм.

1927 оны Хятадын хувьсгал, хятад дахь Коминтернийг баримталсан хүчний ялагдал ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссариат (ГХАК) бодлогоо өөрчлөхөд хүргэв. Уг бодлогын нэгэн шинэ чиглэл нь Нийслэл Өргөөд сууж байсан Оросын элчин сайд А.Н.Васильевийн: "ГХАК-ын баримтлах чиг шугам нь хятадын олон нийтгүй зөрчилдөхгүй байхад оршино. Тиймээс Монгол Улсад суугаа ЗХУ-ын улс төрийн төлөөлөгчийн газар монголчуудын дотор буй хувьсгалч үзэлтнүүдийг бүхийл аргаар хязарлан барьж, хятадын эсрэг

хөдөлгөөн өрнүүлэхээс татгалзахыг ятгана” хэмээн хийсэн мэдэгдэлд тусгалаа олсон байдаг. Тухайн тэр үед Оросын засгийн газрын байр суурь панмонголизмын хөдөлгөөний зорилготой нийцээгүй бөгөөд Коминтерн хийгээд МАХН нь Өвөр монголд “хувьсгалын түймэр” дэгдээх арга ажиллагаанаас татгалзаж арай тунгааж болгоосон бодлого хэрэгжүүлэхэд шилжсэн байна. Ийнхүү арга ажиллагаагаа өөрчилсний гол шалтгаан нь Япон улсын түрэмгий төлөвлөгөө байсан юм. Японы цэргийнхэн монголын асуудлыг дараахи байдлаар шийдвэрлэх байлаа. Үүнд монголын ноёдын нэр хүндийг ашиглан гадаад монголоос зөвлөлтийн нөлөөг шахан зайлуулах; Хятадаас тусгаарласан нэгдсэн Монгол Улс байгуулсныг зарлан тунхаглаад жийрэг (буферийн) улс байгуулах явдал байв.

Японы милитаризм Ази, Номхон далайн бүс нутагт заналхийлэх гол хүч болоод байсан бөгөөд Япон улс Манжуурт цөмөрснөөр нөхцөл байдал улам ноцтой болсон юм. 1939 онд Халхын голд болсон Зөвлөлт Японы дайнд зөвлөлт монголын цэргийн хүчний хамтын ажиллагааны үр дүнд Японы эзлэн түрэмгийлэгчдийг бүт зохив. Монгол Улс ЗХУ-ын үнэнч холбоотныхоо хувьд Эх орны агуа их дайны жилүүдэд ЗХУ-д боломжийнхоо хирээр эдийн засгийн тусламж үзүүлсний дээр өвөр монголд Квантуны армийг бүт ниргэхэд идэвхтэй оролцсон билээ.

1945 оны 2-р сард Крымд болсон бага хурал дээр Монголын асуудлын талаар ЗХУ-ын байр сууриа “Япон улс Монголыг ЗХУ-д довтлох түшиц газраа болгох гэж байгааг бид зөвшөөрөхийг хүсэхгүй” гэж илэрхийлсэн юм. Монгол Улс үндэснийхээ тусгаар тогтнолыг хүсч байгаа. Үүний сацуугаар Монгол Улс Өвөр монголтой нэгдэн нийлэхийн эсрэг байгааг И.В.Сталин цохон тэмдэглэсэн байдаг. Тэрээр: “Мао Зэдуныг гомдоож болохгүй”, учир нь “Өвөр монгол Хятад хоёр бол нэгэн хувьсгалын механизм эд анги мөн” гэдэг байлаа. Гэхдээ “монголын асуудал” дээр Хятадын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлэх нөхцөл л зөвлөлтийн байр суурийг тодорхойлж байсан юм биш. Нөгөө талаар Ар, Өвөр монгол нэгдэж нэг улс байгуулсан нөхцөлд тэр нь Вашингтоны нөлөөнд орохыг үгүйсгэхгүй байлаа. Тиймээс И.В.Сталины үзэж байснаар ЗХУ-ын хувьд оновчтой нөхцөл нь гагцхүү Ар монголыг л Хятадаас тусгаар байлгах явдал байв. “Монголын асуудлыг” зөвлөлтийн эрх ашигт нийцтэйгээр шийдвэрлэх

нөхцөл бол Германийг буулган авсан өдрөөс 3 сарын дотор ЗХУ Японы эсрэг дайн эхлүүлэх үүрэг хүлээх нөхцөлүүдийг нэг нь байлаа. АНУ, Англи улс стратегийн ашиг сонирхолын үүднээс “монголын асуудал” дээр Москвагийн байр суурийг дэмжсэн юм.

АНУ-ын удирдлага Монголын ирээдүйд ихээхэн анхаарал тавьж байсныг 1944 оны 7-р сарын эхээр дэд ерөнхийлөгч Уоллес Монгол Улсад айлчилсан явдал гэрчилнэ. Зөвлөлт Хятадын харилцааны өнөөгийн байдал, дайны дараахи үеийн өрнөлийг судлах гэсэн гол үүрэг зорилгынхоо хажуугаар Уоллес ерөнхийлөгч Т.Рузвельтэд: “Ар монголд эрүүл саруул өрнөл, байлдааны бэлэн байдал, үндсэрхэг үзэл ажиглагдаж байна. Тус улсад зөвлөлтийн хүчтэй нөлөө байгаа ч улс төрийн болон засаг захиргааны эрх мэдэл нь чадварлаг монголчуудын гарт байна. Хятадын нөлөө эргэж сэргэнэ гэсэн аливаа санаа бодол бодит байдалд нийцэхгүй. Харин ч эсэргээр, дайны дараа Ар монголтой нийлэх суртчилгааны ажиллагааг Өвөр монголд явуулахыг төлөвлөж байна. ...” гэж илтгэсэн байдаг.

Зөвлөлт Хятадын хооронд гэрээ байгуулахад хүргэсэн 1945 оны 8-р сарын 14-ний өдрийн зөвлөлт хятадын хэлэлцээрийн үеээр ЗХУ Монгол Улсыг тусгаар тогтноулахын төлөө байр суурьтай байв. Энэ асуудал дээр хятадын тал Москвагийн хүсэлтэд нааштай хандсан ч өөрийн байр сууриа илэрхийлж байлаа. Хэлэлцээрийн явцад Кремльд болсон албан ёсны уулзалт дээр И.В.Сталин хятадын тал ямар учраас монголын төрт ёсыг “шаргуулан хүсэхгүй” байгааг сонирхов. Үүнд нь хятадын төлөөлөгч Хятад улс алдсан газар нутгаа эргүүлэн олж авах зорилготойгоор дайнд оролцсон, Монгол бол алдсан газар нутгийн нэг мөн гэж хариулжээ. Үүний хариуд ЗХУ туслаагүй бол хятадын арми квантуны армийн бут зохиж чадахгүй байсан гэдгийг И.В.Сталин сануулав. 1945 оны 8-р сарын 14-ний өдөр Хятадын гадаад хэргийн сайд Ван Шизэ (Зөвлөлтийн) гадаад хэргийн ардын комисар В.М.Молотовт: “Ар монголын ард түмэн тусгаар тогтнох тухайгаа нэг бус удаа илэрхийлж байсан байдлыг харгалзан үзээд, Японыг даран сөнөөсний дараа Ар монголд бүх ард түмний санал хураалтаар үүнийгээ батлах юм бол Хятадын засгийн газар Ар монголын тусгаар тогтнолыг түүний өнөөгийн хил хязгаарын дотор хүлээн зөвшөөрөх болно” гэсэн цахилгаан утсыг илгээв.

8-р сарын 10-ны өдөр БНМАУ-ын засгийн газар Япон улстай

дайн зарласан тухай мэдэгдэл хийв. Уг мэдэгдэлд: “Гурван зуун жилийн туршид Монгол Улс тусгаар тогтнолынхоо төлөө тэмүүлж ирсэн бөгөөд бид монгол үндэс угсаатнуудаа нэгэн гэр бүлд нэгтгэж бусад ардчилсан улс орнуудын нэгэн адилаар хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа энх тайвнаар оршихыг хүсч байна...” гэсэн юм. Маршал Х.Чойбалсангийн радиогоор хэлсэн үгэндээ: “... чөлөөлөх Улан армийн хамтаар японы фашистуудыг бут ниргэсний дараа л бид нэгдсэн, ахан дүүсийн, аюул түгшүүргүй, тусгаар тогтносон Монгол улсаа байгуулах тухай ярж болно...” гэдгийг онцгойлон цохон тэмдэглэсэн юм. Уг мэдэгдэлд японы эзлэн авсан нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа монгол угсаатанууд болох халх, дөрвөд, торгууд, айхат, буриад, барга, цахар, ордос, хорчин, дариганга, алша, казах, урианхай нарт хандан Японы эсрэг гартаа зэвсэг барин тэмцэхийг уриалав. Уриалгад Өвөр монголын ард түмэнд хандаж: “... монгол ахан дүүс нар минь! Фашист Японыг сөнөөн дарсны дараа бид эрх чөлөө, тусгаар тогтнол, монголчууд бидний хууль ёсны эрх мэдлээ хамтдаа хангаж, нэгэн гэр бүл мэт ахан дүүсийн улс орноо байгуулна...” гэсэн юм.

МАХН-ын Төв хорооноос монголчуудын нэгдэн нийлэх асуудлаархи Монгол Улсын удирдагчдын байр суурийг таниулсан суртал ухуулгын үлэмж материалыг Өвөр монголд тараах шийдвэр гаргав. Гэсэн ч Ар монголын тусгаар тогтнолын талаар ЗХУ, Хятад хоёрын гаргасан хамтарсан шийдвэрийн дагуу Өвөр, Ар монголыг нэгтгэх гэсэн алива үйл ажиллагаа явуулахгүй байхыг Москвагаас Монголын удирдагчдад хатуу чиглэл өгөв. Үүний дагуу ихээхэн хэмжээний ухуулах хуудсыг устгав. Хэдий тийм ч Х.Чойбалсан байр сууриа хадгалж, өвөр монголын удирдагч нартай далдуур харилцаа холбоотой байж, 1945 оны 8-р сарын 28-ны өдөр (Японд эзлэгдсэн газар нутгийг чөлөөлж эхэлсэн өдөр) Шинэ баруун барга хошуны Ин гэгч газар Хөлөнбуйр аймгийн төлөөлөгчдийн их хурал чуулж, их хурлаас БНМАУ-ын засгийн газарт хандсан уриа гаргасан юм:

“Улаанбаатар хот. Засгийн ордонд.

Монгол Улсын ерөнхий сайд, алдарт жанжин маршал Х.Чойбалсан, Бага хурлын дарга Бумцэнд нар танаа хүндэтгэн хандаж байна. Хөлөнбуйр аймгийн монголчууд бид ЗХУ-ын баатарлаг армийн хүчээр японы эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлөгдөж удаан

хүлээсэн эрх чөлөөгөө олж Хөх тэнгэрийн ивээл дор хувь заяагаа өөрсдөө шийдэх түүхэн боломж тохиолоо. Үүнийг Хөлөнбуйрын үндэстэн ард олон бид гурван зуун жилийн туршид мөрөөдөж ирсэн билээ. Монголын мянга мянган ард олны төлөөлөл болох бид эрх чөлөөнийхөө төлөө, тусгаарлан гадуурхах бодлогыг эсэргүүцэх үүднээс бидний зүрх сэтгэлээс урган гарах энэхүү мэдэгдлийг бүхий л сэтгэл санаагаараа баяр бахдалтайгаар монгол туургатан ард олноороо нэгдэж ариун нандин, нэр төртэй төр улсаа байгуулах мэдэгдлийг хийж байна! Хөлөнбуйрын монголчууд их Чингис хаанаас хойш энэхүү агуу их үйлийн төлөө мөнхөд мятаршгүйгээр тэмүүлж ирсэн билээ. Японы дарлалаас салсныхаа дараа энэхүү Их хурлын индэрээс монгол хэл уран зохиол, соёл, өв уламжлал, шашин шүтлэг, шинжлэх ухаан хосолсон хөгжин дэвжих нэгдсэн монгол төр улсаа байгуулах хүсэлтэй байгаагаа бид ёс төгөлдөр тунхаглаж байна.

Эрхэмсэг ноёд та нартаа бидний уриаг өргөн барьж, нэгдсэн монголын төр улсыг байгуулах бидний хүслийг гүн хүнтэдгэн үзэж дэг журмын дагуу түүхэн шийдвэр гаргана гэдэгт гүнээ найднам... Бид сүсэглэн залбирч... хариуг тэсэн ядан хүлээнэм...” гэжээ.

Хэдий тийм ч МАХН-ын удирдлага болон Х.Чойбалсан үндсэрхэг төлөвлөгөөнөөсөө өөрийн эрхгүй татгалзахаас өөр аргагүй болсон юм. Ерөнхий сайдын орлогч Ламжав, Дотоод явдлын сайд Дуйнхоржав, МАХН-ын нарийн бичгийн дарга Намсрай нар Шилийн голд хүрэлцэн ирж “... БНМАУ тусгаар улс болсон, Өвөр монгол үүнд багтахгүй...” гэсэн Өвөр монголчуудын сэтгэлийг туйлийн ихээр гонсойлгосон мэдэгдлийг хийгээд цаашдын хувь заяагаа өөрсдөө шийдэхийг зөвлөв.

1945 оны 10-р сарын 20-ны өдөр БНМАУ-д бүх ард түмний санал хураалт болов. Санал хуралтанд 487400 хүн оролцож тусгаар тогтнолынхоо төлөө 100% саналаа өгөв. Бүх ард түмний санал хураалтын үеэр Завхан аймагт оршин сууж байсан 200 цагаач хятад Хятадын засгийн газарт: “... бид 1921 оноос БНМАУ-д амьдарч байгаа билээ. Бид өөрсдийгөө энэ улсын бүрэн эрхт аз жаргалтай иргэд гэж үздэг. Бидний хувьд хоёр дахь эх орон минь болсон Монгол Улсад хайртай...” гэсэн захидал явуулсан байдаг. Гоминдан нам 1946 оны 1-р сарын 6-ны өдөр санал хураалтын дүнтэй танилцаад БНМАУ-ыг тухайн хил хязгаарт нь тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв. 1946 оны

2-р сарын 28-ны өдөр Москва хотноо Монгол Зөвлөлтийн хооронд найрамдал, харилцан туслах тухай 10 жилийн хугацаатай Гэрээнд гарын үсэг зурав. Уг гэрээгээр ЗХУ анх удаагаа БНМАУ-ыг де-юре хүлээн зөвшөөрсөн юм.

Монголын түүхч Г.Мягмарсамбуугийн үзэж байгаагаар хэдийгээр монгол туургатныг “нэгтгэх” бодлого геополитикийн олон шалтгааны улмаас хэрэгжиж чадаагүй ч тус улсын удирдлага Өвөр монголын хүн амыг БНМАУ-ын нутагт олноороо шилжин суурьшихыг идэвхтэй өөгшүүлэн дэмжих тухай шийдвэрийг гаргсан юм.

Дорнод аймаг дахь улсын архивт буй баримт материалаас харахад 1945 оны 12-р сараас 1946 оны 2-р сарын хооронд Өвөр монголоос БНМАУ-д 679 гэр бүлийн 2798 хүн, үүнээс 1303 эрэгтэй (250 лам), 1495 эмэгтэй шилжин ирсэн байна. Мал сүргийн тоо толгой адуу, бог, бод мал нийт 84406 толгой байжээ. Гол төлөв барга, халх, хорчин, үзэмчин, буриадууд байжээ. 1946 оны 2-р сарын 25-ны өдөр тус аймгийн удирдлага Өвөр монголоос шилжин суурьшигчдыг аймгийн төвөөс баруун хойд зүгт Хэрлэн голын сав нутагт бөөнөөр нь суурьшуулах шийдвэр гаргав. 1946 оны 4-р сарын 24-ний өдөр Улсын Бага хурлаас БНМАУ-ын иргэн болох хүсэлтэй монголчуудад эд материалын тусламж үзүүлэх, Чойбалсан, Баянхонгор, Дундговь аймгийн нутагт бэлчээр нутаг олгох тухай тогтоол батлав.

БНМАУ-ын удирдлагын зүгээс Монол Улсад шилжин суурьшсан өвөр монголчуудад үзүүлсэн эерэг зүйлүүдийн зэрэгцээ олон хүнийг хэлмэгдүүлж тэдний амьдрал хувь заяанд нь сөргөөр нөлөөлсөн үйл явдлыг судлах нь чухал гэсэн монголын түүхч Г.Мягмарсамбуугийн дэвшүүлсэн саналыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. БНМАУ-д сайн дураараа шилжин суурьсан хүмүүсээс гадна гол төлөв японы эзлэн түрэмгийлэгчдийн өөрийн цэрэгт хүчээр элсүүлж зөвлөлт монголын цэргийн эсрэг байлдааны үйл ажиллагаандаа ашиглан оролцуулсан цэргийн олзлогсод хэмээгдсэн монголчууд байсан юм. Г.Мягмарсамбуугийн нотлож байгаагаар эдгээр хүмүүсийн цаашдын хувь заяа нь Монгол Улсын түүхэнд “цагаан толбо” болон үлджээ; тэр үеийн эмгэнэлт явдлаас амьд сэрүүн үлдсэн цөөн хүн өөрсдийгөө хууль бусаар хэлмэгдсэн гэж үзэж төрөөс тэдний цагаатгана гэж найдсаар байгаа юм. Төрөөс явуулсан бодлог гүй харгис ширүүн явуулгын

улмаас үлэмж тооны өвөр монголчууд 1947-1950 онд БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орон руугаа буцсан юм.

Зохиогч БНХАУ-ын дарга Си Зиньпины өвөг дээдэс 70 жилийн өмнө сайн дураараа БНМАУ-д сайн дураараа суурьшин амьдарч байсан гэснийг нотлох гээгүй ч монголын зарим нийтлэлчид ингэж үздэг. Үүний шууд бус баталгаа болгож БНМАУ-ын МАХН-ын Төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын нэгэн удаа Бээжинд хийсэн айлчлалын үеэр 10 настай Си Зиньпин түүнд цэцгийн баглаа барьж байгаа гэрэл зургийг иш татдаг.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалах гэсэн ЗХУ-ын хүчин чармайлт үүгээр төгсгөл болоогүй юм. Мао Зэдун тэргүүтэй ХКН гоминдан намыг бүрэн ялахаас өмнөхөн 1949 оны 2-р сард И.В.Сталин ЗХУ-ын ерөнхий сайдын нэгдүгээр орлогч А.И.Микояныг нууц үүрэгтэйгээр ХКН-ын даргатай уулзуулахаар Хятадад томилсон юм. Микояны И.В.Сталинд өгсөн илтгэлд: “Мао Зэдун Ар болон Өвөр монголын нэгтгэх тухай санал дэвшүүллээ. Үүнд нь би энэ бол Хятад улсад хортой, тиймээс дэмжиж болохгүй санал гэж хариулсан. Тэгэхэд Ар Өвөр монголыг нэгтгээд БНХАУ-д харъяалуулах юм гэж Мао Зэдун тайлбарлав. Үүнд нь би БНМАУ нэгэнт тусгаар тогтнолоо олчихоод байхад энэ байж болохгүй гэж хариулаад Хятад улс Ар монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн шүү дээ гэдгийг санууллаа...” гэжээ.

1950 онд Москва хотод Зөвлөлт Хятадын хооронд харилцан туслах гэрээнд гарын үсэг зурах үеэр явагдсан албан ёсны хэлээлцээр дээр Мао Зэдун Монголын тухай асуудлыг дахин хөндөөгүй юм. Уг гэрээнд Хятад улс нь Монгол Улсын тусгаар тогтнолыг түүний өнөөгийн хил хязгаарын дотор хүлээн зөвшөөрнө гэсэн байдаг. Хэдий тийм ч 1954 онд Н.С.Хрущёвын Бээжинд хийсэн айлчлалын үеэр албан бус байдалд Мао Зэдун түүнд: “... Монголын асуудал шийдэгдээгүй байгаа” гэсэн мэдэгдэл хийсэн байдаг.

Сонирхол татах нэг баримт гэвэл 1956 онд японы депутатууд польшийн Сеймийн депутатуудад Монгол бол алдагдсан газар нутаг гэж нотлохыг оролдож байжээ...

Орос эхээс орчуулсан Ж.Болд

Ном зүй

1. Баабар – история Монголии: от мирового господства до советского сателлита – Казань: Татар. кн. изд-во, 2010. 542-р нүүр
2. Богатуров А.Д. Великие державы на Тихом океане. История и теория международных отношений в Восточной Азии после Второй мировой войны (1945-1995). М.: Конверт-МОНФ, 1997. 353-р нүүр
3. Галенович Ю.М. “Белые пятна” и “болевые точки” в истории советско-китайских отношений от октября 1917 г. до октября 1949 г.: в 2 т. Т.1.-М.: ИДВ, 1992. 140-р нүүр
4. Дьяченко Н.Е. К вопросу о панмонголистском движении // Востоковедные исследования на Алтае. –Барнаул: Барнаул. гос. ун-т, 2012. –Вып.3. 182-192-р нүүр
5. К.Дэмбэрэл. Влияние международной среды на развитие Монголии: сравнительный анализ в историческом контексте XX века. – Иркутск: Отгиск, 2001. 121-р нүүр
6. Мягмарсамбуу Г. “Чөлөөлөх дайн ба голмтоо зорьсон монголчууд”. Монголия и Россия в годы Второй мировой войны. – Улаанбаатар; Улан-Удэ, 2011.

